



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,  
Цахим шуудан: info@namem.gov.mn

2026. 04.23 № 01/321  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хариу хүргүүлэх тухай**

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн инженер Д.Энх-Эрдэнийн гаргасан Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт гаргасан “Орхон аймгийн УЦУОШТ-д хяналт шалгалт хийж, дарга С.Отгонбаатар, Цаг уур технологи, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Д.Оюунбат, Захиргаа төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Хандмаа нарын хууль бус үйлдэлд хариуцлага тооцож өгнө үү” гэх агуулга бүхий гомдлыг шилжүүлснийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5-д заасны дагуу дотоод хяналт, шалгалт хийлээ.

1. Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт гаргасан гомдолд дурдсан зарим асуудлаар Д.Энх-Эрдэнэ өмнө нь нийт 3 удаа гомдол гаргасан байна.

2. Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны Б/09 дугаартай тушаалаар Д.Энх-Эрдэнэ ажлаас халагдаж Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд гомдол гаргаж 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцэн ажилдаа эргэж орох шийдвэр гарсан байна.

3. Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд 2024 оны 07 дугаар сарын 08-наас Д.Энх-Эрдэнэ нь “Эрдэнэт-Овоо” цаг уурын өртөөнд техникчээр туршилтын түр гэрээ байгуулан ажилд орж туршилтын хугацаа нь дуусаад урьдчилан мэдээлэхийн инженерийн орон тоо дээр дагалдан ажиллаж байгаад ажлаас халагдсан асуудлаар Иргэн Д.Энх-Эрдэнэ ёс зүйн хороонд гомдол гаргаж, ЦУОШГ-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ны Б/67 дугаартай тушаалаар Орхон аймгийн УЦУОШТ-ийн дарга С.Отгонбаатарт ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн байна.

4. Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт гаргасан ижил агуулгатай гомдлыг Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн инженер Д.Энх-Эрдэнэ нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисст гаргасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос 3 хүний бүрэлдэхүүнтэй баг Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд хяналт шалгалт хийсэн байна.

5. Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 318/ШШ2025/02194 дугаартай шийдвэрээр урьдчилан мэдээлэхийн инженерийн албан тушаалд үндсэн ажилтнаар 2025 оны 12 дугаар сарын 01-ээс ажиллаж эхэлсэн байна.

6. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний А/162 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний

1526020280

d:\2026\тоот\04.23-321.docx

